



ХҮНИЙ ЭРХИЙН ТӨРИЙН БУС БАЙГУУЛЛАГУУДЫН ФОРУМ

2020 оны 06 сарын 18 өдөр

Улаанбаатар хот

МЭДЭГДЭЛ

Хүний эрхийн форум нь Коронавирусийн халдвар (COVID 19)-ын цар тахлын дэгдэлт дэлхий нийтийг түгшээж буй энэ үед явагдаж буй Монгол Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн үеэр хүний эрхийн олон улсын хэм хэмжээ мөрдөгдөж буй эсэхэд хөндлөнгийн ажиглалт, дүгнэлт хийхийг зорьж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн 16 дугаар зүйлийн 16.9-д иргэний сонгох, сонгогдох эрхийг баталгаажуулсан. Мөн Монгол Улс 1974 онд соёрхон баталсан Иргэний болон улс төрийн эрхийн тухай олон улсын Пактын 25 дугаар зүйлийн 25 (b)-д сонгогчид жинхэнэ хүсэл зоригоо чөлөөтэй илэрхийлэх боломжийг баталгаажуулсан байхыг заасан билээ. Иргэний сонгох, сонгогдох эрхийн баталгааг хангах үүргийг төр хүлээдэг. Энэ хүрээнд нэг баталгааг дурьдахад Монгол Улсын Их Хурлын сонгуулийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2-т “Сонгууль бүх нийтийн байх бөгөөд түүнд сонгогч бүр оролцох эрхтэй.” хэмээн заасан. Гэвч цар тахлаас урьдчилан сэргийлж, тэмцэж буй энэ цаг үед сонгуулийн бүх нийтийн байх зарчмыг нэг мөр хэрэгжүүлэхэд сайн зохион байгуулалт, мэдлэгтэй мэдээлэлтэй сонгогчдын оролцоо чухал болохыг цар тахлын дэгдэлтийн үеэр сонгуулиа амжилттай зохион байгуулсан улсын туршлага харуулж байна. Тийм ч учраас МУ-ын Засгийн газар 188-р Тогтоолоор баталсан “МУ-ын УИХ-ын 2020 оны ээлжит сонгууль зохион байгуулах үйл ажиллагааны явцад Коронавируст халдвар (КОВИД-19)-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх журам”-ын 2.1.1-т **“хүний амь нас, эрүүл мэнд, аюулгүй байдал, нийтийн ашиг сонирхлыг хамгаалах, халдвараас урьдчилан сэргийлэх”** хэмээн тодотгосон. Гэтэл сонгуулийн үйл явцын бүх шатанд (сонгогчийн бүртгэл, сонгуулийн ажилтан бүртгэх ба сүргэх, нэр дэвшигчдийг томилох, улс төрийн кампанит ажил, худалдан авалт ба сонгуулийн маргаан шийдвэрлэх) ялангуяа, санал авах явцад сонгогч бүр, түүний дотор 65-аас дээш насны болон эрүүл мэндийн суурь нөхцөлтэй эсвэл бусад байдлаар эрсдэлт бүлэгт багтах сонгогчдын сонгох эрхээ эдлэх боломжийг хангах хүрээнд Сонгуулийн ерөнхий хорооноос халдвараас сэргийлэх чиглэлээр авч байгаа болон авах гэж буй арга хэмжээний тухай сонгогчид мэдээлэлгүй байгааг анхааруулж байна.

Сонгуулийн сурталчилгаа ид идэвхжиж буй энэ нөхцөлд нам, нэр дэвшигчид цар тахлын үед мөрдөх хууль, дүрэм журмыг илт зөрчиж буйд бид харамсаж байна. Аливаа сонгууль улс төрийн чухал ач холбогдол бүхий үйл явдал хэдий ч иргэдийн амь нас, эрүүл мэндийг хамгаалах, аюулгүй байдлыг хангах нь цар тахлын нөхцөл байдалд нэн тэргүүний зорилт

байх ёстой. Иймд санал хураах байранд биеэ хэрхэн авч явах, өөрийн болон бусдын эрүүл мэндийг хамгаалахад анхаарах зөвлөмж, журмын тухай таниулгаа идэвхжүүлэн сонгогч бүрийн ухамсарт нөлөөлөхгүй бол сонгогчдын аюулгүй байдал, эрүүл мэндээ хамгаалуулах эрхэд эрсдэл үүсч болзошгүй байгааг сануулж байна.

Ардчилал, сонгуульд дэмжлэг үзүүлэх олон улсын хүрээлэн (IDEA)-ээс КОВИД-19-ийн үеэр сонгууль зохион байгуулсан таван улсын туршлагыг судалсны үндсэн дээр сайн туршлагыг хуваалцсан бөгөөд үүнд зөөврийн хайрцгаар, урьдчилан эсхүл шуудангаар санал авах зэргээр нэг дор олноор цугларах эрсдлийг бууруулах арга хэмжээг авсан тухай дурьдсан байна. Тиймээс иргэд сонгох эрхээ аюулгүй, эрсдэлгүй нөхцөлд эдлэх боломжийг бүрэн дүүрэн хангахуйц зохион байгуулалтыг хийх, энэ тухай мэдээ, мэдээллийг сонгогчдод тухай бүрд хүртээмжтэй хэлбэрээр хүргэх, мөн цар тахлаас сэргийлэх хүрээнд баталсан дүрэм журмыг зөрчиж буй үйлдэлд тухай бүрд хариуцлага тооцож ажиллахыг уриалж байна.

Сонгуулийн **бүх нийтийн зарчим** нь сонгуулийн насны, эрх бүхий сонгогч нэг бүр сонгуульд оролцож, сонгох эрхээ эдэлж чадсан эсэхээр хэмжигдэх тул сонгогч бүрийн, тэр дундаа эмзэг бүлгийн сонгогчдыг сонгуульд аюул, эрсдэлгүй оролцож, сонгох эрхээ эдлэх боломжийг бүрдүүлж ажиллахыг анхааруулж байна.

ХҮНИЙ ЭРХИЙН ФОРУМ